

НАЛАЙХ ДҮҮРГИЙН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ, АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2018 ОНЫ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН БИЕЛЭЛТ

2018 оны 03 дугаар сарын 26

Налайх дүүрэг

Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	№	Үйл ажиллагаа хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
1	2	3	4
<p><b>Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр</b></p>			
4.1.1.1. Төрийн албаны төв байгууллагын	1.	Сул орон тооны мэдээллийг байгууллагын цахим хуудаст байрлуулах	Төрийн жинхэнэ албан хаагчийн үүргийг түр орлон гүйцэтгэх журмын 4.8-д заасны дагуу 1, 4 дүгээр хорооны нийгмийн ажилтны албан тушаалд төрийн албанд анх орох иргэний нөөцөд бүртгэгдсэн иргэдээс сонгон авч хугацаа заан түр томилсон.Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасныг дагуу 6 дугаар хорооны зохион байгуулагчийн албан тушаалд, Төрийн жинхэнэ албан хаагчийн үүргийг түр орлон гүйцэтгэх журмын 4.9-д заасны дагуу Хот төлөвлөлтийн хэлтсийн Орон сууц, реклам-гэрэлтүүлэг чимэглэл, харилцаа холбоо-мэдээллийн байгууламж хариуцсан мэргэжилтний албан тушаалд тус тус түр томилогоо хийгдсэн. Дүүрэгт “Хүүхдэд ээлтэй орон нутаг” төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаатай холбогдуулан тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн Д.Тунгалагтай 3 сарын хугацаатайгаар гэрээ байгуулан ажилласан.
	2.	Удирдах ажилтны сул орон тоог нөхөхөд хувийн ашиг сонирхлын	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалын сул орон орон тооны захиалгыг хүргүүлэн

<p>дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх;</p>		<p>урьдчилсан мэдүүлгийг АТГ-аар хянуулж, дүгнэлт гаргуулан томилох</p>	<p>сонгон шалгаруулалтыг зарлуулсан. Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлөөс Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцийн бүртгэлээс нэр дэвшүүлсэн Ж.Алтангэрэлийг томилсон шийдвэрийг гаргаж, хүргүүллээ. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, төрийн албан хаагчийн анкет, бусад шаардлагатай баримт бичгийг хянуулахаар О.Энхтайваны материалыг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, зөрчилгүй талаарх дүгнэлтийг хүлээн авч томилгоог хийлээ. Үүний дагуу албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг гаргах эрхийг нээн мэдүүлгийг цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай баталгааны маягтыг хүлээн авч бүртгэл үйлдэн, хянан баталгаажууллаа.</p>
	<p>3.</p>	<p>Дүүрэгт ажиллаж буй нийт төрийн албан хаагчдийн судалгаа гаргах</p>	<p>Налайх дүүргийн төрийн албаны нөөцийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бий болгох зорилгоор байгууллагын хүний нөөцийн мэдээллийг маягтын дагуу гаргаж ирүүлэх тухай албан бичгийг 36 байгууллагад хүргүүлж, 32 байгууллагаас хүлээн аваад байна</p>

<p>4.1.1.6. Нийтийн албаны ёс зүйн үлгэрчилсэн дүрмийг батлах, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг хэвшүүлэх;</p>	1	<p>Төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг цахим хуудсанд байршуулах</p>	<p>Мөн Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн 5, Тохижилт, нийтийн үйлчилгээний хэлтсийн 2, Санхүү, төрийн сангийн хэлтсийн 2 албан тушаалын ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулах тухай Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны Б/16 дугаар тушаалаар батлуулан өөрчлөлт хийгдсэн. “Налайх Хангамжийн төв” ОНӨААТҮГ-ын даргын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан гаргаж батлуулсан.</p> <p>Smartcity.mn нэгдсэн системд оруулах төрийн албан хаагчдын мэдээллийг гаргаж шинэчлэлтийг хийлгэлээ.</p>
	2	<p>Тамгын газрын ёс зүйн дүрмийг шинэчлэн батлуулж цахим хуудсанд байршуулан хэрэгжилтийг ханган ажиллах</p>	<p>Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны А/03 дугаар тушаалаар батлуулан дүүргийн цахим хуудсанд байршууллаа.</p>
	3	<p>Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тодорхойлох</p>	<p>Хугацаа болоогүй.</p>

<p>4.1.1.7. Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх</p>	<p>1</p>	<p>Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой иргэн, байгууллага албан тушаалтаас ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх</p>	<p>Байгууллагын удирдлагын ёс зүйтэй холбоотой 1 өргөдөл гомдол ирсэн. Тухайн өргөдлийг өргөдөл, гомдлын нэгдсэн програм smartcity.mn-д бүртгэж холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн. Хуулийн хугацаанд судлагдаж байна.</p>
<p>4.1.1.9. Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл боломжийг сайжруулах;</p>	<p>1</p>	<p>Албан хэрэг хөтлөлтийн edoc.ub.gov.mn системд тоон гарын үсэг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлж, баримт боловсруулалтанд ашиглаж, хэвшүүлэх</p>	<p>Нийслэлийн мэдээллийн технологийн газраас дүүргийн Засаг дарга, дүүргийн Засаг даргын орлогчийн 2, Засаг даргын Тамгын газрын дарга, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Тохижилт, нийтийн үйлчилгээний хэлтэс, Хот, төлөвлөлтийн хэлтсийн даргын нийт 8 ширхэг тоон гарын үсгийг битүүмжлэн ирүүлээд байна.</p>
<p><b>Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх, чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр:</b></p>			
	<p>1</p>	<p>Иргэдээс ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг smartcity.mn нэгдсэн програмд бүртгэн, шийдвэрлэлтэд хяналт тавих</p>	<p>Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2018 оны нэгдүгээр улирлын байдлаар бичгээр ирүүлсэн 50 өргөдөл, Засгийн газрын 11-11 төвөөс 20, нутгийн захиргааны байгууллагын 70232727 утсаар 10 гомдол, хүсэлтийг хүлээн авч Засаг даргын дэргэдэх байгууллага, алба, хэлтэс болон тэдгээрт хамааралтай асуудлаар гаргасан гомдол, хүсэлтийг тухайн байгууллага, нэгжид шилжүүлж, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна. Дүүргийн хэмжээнд нэгдүгээр улирлын байдлаар нийт 246 өргөдөл, гомдол өргөдөл гомдлын нэгдсэн програм “Smart city”-д бүртгэгдсэн байна. Хугацаандаа шийдвэрлэгдсэн 213 өргөдөл,</p>

4.1.2.6. Өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл, гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх;			гомдол байна. Хуулийн хугацаанд судлагдаж, хүлээгдэж байгаа 33 өргөдөл байна. Иргэнд хариуг тухай бүр хүргэн ажиллаж байна. Засаг даргын тамгын газрын нийт өргөдөл гомдлын шийдвэрлэлт 93,75 хувьтай байна. Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног 22 цаг 16 минут байна. Хугацаа хэтэрч, хугацаа сунгаж шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй болно.
	2	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх	Хугацаа болоогүй.
<b>Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр:</b>			
4.1.3.1. Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх;	1	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж холбогдох мэдээллийг батлагдсан журмын дагуу цахим хуудсанд байршуулах	Төсөвт байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулсан байдалд улирал бүр хяналт тавин гүйцэтгэлээр үнэлгээ өгч ажиллаж байна. Тайлант оны 1-р улиралд төсөвт байгууллагуудын мэдээлэл байршуулсан байдлыг 36 байгууллагад хяналт хийж үнэлгээ өгсөн. Үнэлгээгээр 42.7-оос 100 хувь үнэлэгдсэн

			байна.
	2	Ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй зөрчилд мэдэгдэл, тайлбар гаргуулах, тэдгээрийг бүртгэх, тайлан мэдээ гаргах	Дүүргийн Засаг даргын захирамжийн төсөлд санал авах хуудсанд “Ашиг сонирхлын зөрчилтэй эсэх” тэмдэглэгээ, тайлбарыг оруулж өгснөөр албан тушаалтнууд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргаж хэвшсэн. Тайлант хугацаанд 1 албан тушаалтан гаргасныг удирдлагад танилцуулан шийдвэрлүүлсэн.
4.1.3.2. Төсвийн төлөвлөлтийн үр ашигтай байдал, гүйцэтгэл, зарцуулалтын хөндлөнгийн хяналт, хариуцлагыг дээшлүүлэх;	1	Улс, нийслэл, дүүрэг, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлыг иргэдэд мэдээлж байгууллагын сайтад байршуулах	Дүүргийн 2018 оны 371.3 мянган төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 23 ажил хэрэгжүүлэхээр ИТХ-аар хэлэлцэж баталсанаас 5 дугаар хорооны уурын зууханд БЗУИ 100 маркийн зуух суурилуулсан ажлын гүйцэтгэлийг хүлээн авч актаар баталгаажуулан бичиг баримтын бүрдлийг хангаж 15.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. 3 хорооны камержуулалтын ажилд гүйцэтгэгч нь шалгарсны дагуу гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг хүргүүлэн гэрээний төслийг боловсруулан 15 ажлын техникийн даалгаврыг холбогдох хэлтсээс авч гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлуулахаар Худалдан авах ажиллагааны албанд хүсэлт хүргүүлсэн. Дүүргийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан ажлуудаас 1 ажил шууд гэрээ байгуулахаар, 6 ажил байршил солигдох болон зориулалт өөрчлүүлэхээр хороодын иргэдээс хүсэлт ирүүлсэнийг хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэхээр хүлээгдэж байна. 2013-2016 онуудад Нийслэл болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн барьцаа дансанд байршиж буй 71 ажлын 72,205.2 мянган төгрөгийн үлдэгдлээс барьцаа чөлөөлөх хугацаа

			<p>дууссан 9 ажлын гэрээ дүгнэсэн протокол үйлдэж, барьцаа хөрөнгийг чөлөөлөх хүсэлтийг орон нутгийн хөгжлийн сан хариуцсан нягтлан бодогчид холбогдох бичиг баримт болон санхүүжилтийн мэдэгдэл хүргүүлж олгуулсан. Дүүргийн ОНХС-ийн 2018 оны хөрөнгөөр хэрэгжих 23 ажлын мэдээг Сангийн яамны <a href="http://www.mof.gov.mn/ОНХС/">www.mof.gov.mn/ОНХС/</a> цахим хуудсанд байршуулсан.</p>
<p><b>Дөрөв. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр:</b></p>			
<p>4.1.4.1. Тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх;</p>	<p>1</p>	<p>Худалдан авах ажиллагааг цахимжуулж, зарлагдсан тендерийг сайтад тогтмол байршуулан “Шилэн тендер”-ийн тогтолцоонд шилжүүлэх ажлыг эхлүүлэх</p>	<p>2018 онд бүх тендерийг цахим хэлбэрээр зохион байгуулахаар тусгай зориулалтын Үнэлгээний хорооны өрөөг шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр бүрэн тохижуулан ашиглалтанд оруулсан бөгөөд “3 дугаар хороонд камер суурилуулалт хийх”, “Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй 1 дүгээр хорооны Энгэр шанд хэсэгт ахмад настан, хүүхэд залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх, тоглоомын талбай байгуулах”, “3 дугаар хороонд хог гаднаас нь ачдаг хогийн бункер хийх” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерүүдийг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn-д</a> цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулж байна. Гэвч хувь хүнд тоон гарын үсэг олгох боломжгүй байгаатай холбогдуулан олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах боломжгүй байгаа тул уламжлалт хэлбэрээр зохион байгуулж байна. Мөн цахим худалдан авах ажиллагааны систем болох <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим хуудаст тендерийн урилгыг тухай бүр нийтэлж, үр дүн гэрээний</p>

			хэрэгжилтийн талаарх мэдээллийг оруулж байна.
4.1.4.2. Тендер шалгаруулалтын талаар гарсан гомдлыг хянан шийдвэрлэх журмыг шинэчлэх, гаргасан шийдвэр, дүгнэлтийг олон нийтэд ил тод болгох;	1	Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулах	1 дүгээр улирлын байдлаар зарлагдсан 12 тендерийн урилгыг “Монголын мэдээ” сонин, <a href="http://www.nalaikh-tender.ub.gov.mn">www.nalaikh-tender.ub.gov.mn</a> , <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим хуудаст тус тус зарлагдсан өдөр нэгэн зэрэг нийтэлсэн бөгөөд цахим хэлбэрээр зарласан 3 тендерийн баримт бичгийг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> -д нээлттэй ил тод байршуулсан. Мөн албаны гадна самбарт зарлагдаж буй тендерийн урилга болон 2018 оны худалдан авалтын ерөнхий төлөвлөгөөг нийтэлж байна.
	2	Нийслэл дүүргийн захиалгаар төсөл хөтөлбөрт шалгарч гэрээний үүргээ биелүүлээгүй байгууллагын хар жагсаалтыг гаргаж, нийтэд мэдээллэх, дахин оролцох боломжийг хязгаарлах	Тендер шалгаруулалтад ирүүлсэн оролцогчдын материалыг үнэлэхдээ нарийвчлан хянаж, илт худал мэдээлсэн болон баримт бичгийг хуурамчаар үйлдсэн аж ахуй нэгжийг Сангийн яаманд тухай бүр мэдэгдэхээр чиглэл барин ажиллаж байна.
4.1.4.3. Худалдан авах ажиллагааны бодлого, төлөвлөлтийг сайжруулж, ил тод болгох, олон нийтээр урьдчилан хэлэлцүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх;	1	Худалдан авах ажиллагааны жилийн тайланг гаргаж сайтад байршуулах	Худалдан авах ажиллагааны албаны 2017 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын тайланг албаны <a href="http://www.nalaikh.tender.ub.gov.mn">www.nalaikh.tender.ub.gov.mn</a> цахим хуудаст 01 дүгээр сарын 25-ны өдөр, 2018 оны 1 дүгээр улирлын тайланг 03 дугаар сарын 23-ны өдөр тус тус нийтэлсэн.
<b>Тав. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах зорилтыг хангах чиглэлээр:</b>			
4.1.5.13. Хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан тушаалтны хүрээг оновчтой	1	Мэдүүлгийг цахим хэлбэрээр авах, хянах, баталгаажуулах	Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт төрийн захиргааны албан хаагчид болон хуулийн үйлчлэлд хамааран 2017 оны ХАСХОМ гаргах 28 албан тушаалтны судалгааг хүргүүлж, мэдүүлгийг хуулийн



<p>ТОГТООЖ, МӨРДӨХ;</p>			<p>хугацаанд гаргуулан, хянан баталгаажуулан бүртгэж, тайлан мэдээг нэгтгүүллээ.</p> <p>“Налайх Хангамжийн төв” ОНӨААТҮГ-ын даргын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг гаргах эрхийг нээн мэдүүлгийг цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай баталгааны маягтыг хүлээн авч бүртгэл үйлдэн, хянан баталгаажууллаа.</p>
<p><b>Зургаа. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах чиглэлээр:</b></p>			
<p>4.1.6.3. Төр, хувийн хэвшлийн болон хувийн хэвшил хоорондын авлигаас урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааг өргөжүүлж, аливаа санал, санаачилгыг дэмжиж, хамтран ажиллах;</p>	<p>1</p>	<p>Тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахад шаардлагатай баримт бичгийн жагсаалтыг гарган байгууллагын сайтад ил тод нээлттэй байрлуулах</p>	<p>2017 онд тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт, тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахад шаардлагатай баримт бичгийн жагсаалтыг гаргаж, дүүргийн цахим хуудсанд байршуулсан. 2018 оны 1 дүгээр улирлын байдлаар тамхины тусгай зөвшөөрлийг 7 аж ахуйн нэгжид олгоод байна.</p>
<p><b>Долоо. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр:</b></p>			
<p>4.1.10.1. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх;</p>	<p>1</p>	<p>Авлигад өртөж болзошгүй Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбаруудад авлигад өртөж байгаа эсэх талаар иргэдээс явуулын хайрцагаар санал авах</p>	<p>Хугацаа болоогүй.</p>